



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН
/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ/

2017.12.29

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ хийх зорилго нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хангахад чиглэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар дүгнэлт гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Эрх зүйн үндэслэл нь “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоол, “Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2017 оны 29 дүгээр тогтоол, “Төлөвлөгөө батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 63 дугаар тушаал болно. Эдгээр тогтоол, тушаалын заалтын дагуу хэрэгжүүлсэн ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээний тайлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба энэ нь Засгийн газраас тус яамны үйл ажиллагааг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болохын зэрэгцээ яамны ерөнхий менежер, нэгжийн менежерүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн түвшинг үнэлж, дүгнэх нэг үзүүлэлт болох ач холбогдолтой.

Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшингийн хувийг тогтоохдоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг баримталсан болно.

Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн явц

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 63 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Тус төлөвлөгөөнд Зам, тээврийн салбарт 6 зорилтыг хэрэгжүүлэх 36 арга хэмжээ төлөвлөсөн.

УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан 7.4.2. “Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төв байгуулах бэлтгэл ажлын явцыг 100 хувьд хүргэх” арга хэмжээг ЗГ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 63 дугаар тушаалаар батлагдсан МУ-ын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр тусгасан зорилт, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөнд тусгаагүй байсныг нэмж нийт 37 арга хэмжээний хэрэгжилтийг үнэллээ. Үүнд:

- Авто замын салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 18 арга хэмжээ
- Төмөр зам, далайн тээврийн салбарт 3 зорилтыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээ
- Агаарын тээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 9 арга хэмжээ
- Автотээврийн салбарт 1 зорилтыг хэрэгжүүлэх 1 арга хэмжээ



Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын дагуу Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 37 арга хэмжээний хэрэгжилтийг 2017 оны дүнгээр авч үзвэл 3 арга хэмжээ үнэлэх боломжгүй байгаа ба бусад 34 арга хэмжээ **дунджаар 83.2 хувийн биелэлттэй** үнэлэгдлээ.


Хэрэгжилтийг давхардсан тоогоор газар, хэлтэс тус бүрээр авч үзвэл:

Хүснэгт 1

№	ГАЗАР, ХЭЛТЭС	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломжгүй	Хувь
1	БТГ	19	9	7	1	-	2	84.1
2	АЗБХЗГ	18	12	4	1	-	1	89.4
3	АТБХЗГ	1	-	1	-	-	-	70
4	ТЗДТБХЗГ	8	1	5	2	-	-	66.2
5	АТБХЗХ	9	5	3	-	-	1	88.7
6	ТЗУГ	2	-	1	-	-	1	70
7	ХШҮДАГ	8	6	2	-	-	-	92.5
Нийт		37	18	13	3	-	3	83.2


Нийт арга хэмжээний хэрэгжилтийг газар, хэлтсээр тус бүрээр ангилж үзүүлбэл:

Зураг 1



Нийт арга хэмжээг хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

Зураг 2



Гурав. Дүгнэлт

Хэрэгжилтийн хувьд авч үзвэл 2017 оны жилийн эцсийн байдлаар үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 18, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 13, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 3, үнэлэх боломжгүй 3 арга хэмжээ байна.

Дараах шалтгааны улмаас доорх 3 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт 2

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
7.2.8	“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн Багц-4: Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Тус багц хэсгийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд 2015 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр тендерт оролцогчоос Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан бөгөөд шүүхийн шийдвэр гартал барилгын ажлыг түр түдгэлзүүлсэн. Шүүхийн шийдвэр 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр гарсан. Барилгын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Чайна Хуаши Энтерпрайзиз Лимитед” компани гэрээ цуцлах хүсэлт ирүүлсэн бөгөөд гэрээг холбогдох хүсэлтийн дагуу 2017 оны 06 сарын 30-ны өдөр цуцалсан. Азийн хөгжлийн банкны зөвлөмж болон холбогдох журмын дагуу дахин зам барилгын ажлыг гүйцэтгэх олон улсын тендерийг 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зарласан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх тухай албан бичиг ирснээр гүйцэтгэчийг сонгон шалгаруулах олон улсын өрсөлдөөнт тендерийг цуцалсан. Шүүхийн шийдвэрийн дагуу "Алтайн зам" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл өгч гэрээний хэлэлцээр хийгдэж байгаа хэдий ч АХБ-наас "Алтайн зам" ХК-тай байгуулсан гэрээг санхүүжүүлэх боломжгүй талаар 2017.11.15-ны өдрийн албан бичгээр мэдэгдээд байна.
7.4.2	Хөшигийн хөндийд	Хөшигийн хөндийн тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ

	<p>холимог тээврийн логистикийн төв байгуулах бэлтгэл ажлын явц, хувиар /100%/</p>	<p>боловсруулах хөрөнгийн асуудал шийдвэрлэх ажлын хүрээнд МУ-ын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтад танилцуулга хүргүүлсэн.</p> <p>АХБ-наас 2017-ны санхүүжүүлэх төслийн жагсаалтад Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах асуудал тусгагдаагүй.</p> <p>Үндэсний тээвэр логистикийн сүлжээний зураглал гаргах ажлын даалгавар боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр ТНБД-аар батлуулсан.</p> <p>Богдхан уулыг тойрох төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр – 01 чигийн судалгаа (48329-001)-ны төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй түншлэл шалгарч “УБТЗ” ХНН-ийн Мандал өртөөнөөс Багахангай чиглэлд шинээр барих “Богдхан” төмөр зам төслийн чигийн судалгаа хийх гэрээ байгуулан 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс чигийн судалгааны ажлыг эхлүүлсэн.</p> <p>Тус судалгааны ажлын эхлэлийн тайланг зөвлөх компани ирүүлсэн. Эцсийн тайлангийн төслийг ЗТХЯ-нд урьдчилан ирүүлснийг судлан үзэж нэмэлт саналуудыг хүргүүлсэн. Чигийн судалгааны эцсийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 15-нд ЗТХЯ-нд хүлээлгэн өгсөн.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын эхлэл болон төгсгөлийн цэгийг тодорхойлох ажлын хэсгийг ТНБД-ын 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн тушаалаар байгуулж “УБТЗ” ХНН-ийн Мандал, Багахангай өртөөнөөс салаалах эхлэл, төгсгөлийн цэгийг тодорхойлсон.</p> <p>Зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017 оны 09 дүгээр арын 22-ны өдөр ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг ЗГ-ын хуралдаанаар батлуулах шийдвэр гарсан.</p> <p>Энэ ажил хийгдсэний дараа Хөшигийн хөндийн тээврийн логистикийн төв байгуулах байршил, ТЭЗҮ хийх үндэслэл бүрдэнэ.</p>
<p>7.5.7</p>	<p>Олон улсын шинэ нисэх буудал ашиглалтад орохтой холбоотойгоор “Чингис Хаан” ОУНБ-ыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах. /100%/</p>	<p>ЗТХ-ийн сайдын 2016 оны 70 дугаар тушаалаар баталсан ИНЕГ-ын бүтцэд Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах ашиглалтын өмнөх захиргааны албыг байгуулсан. Ашиглалтын өмнөх захиргааны алба нь “Чингис Хаан” ОУНБ-ыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг Японы консорциумтай хамтран шинэчлэн боловсруулж, ЗТХЯ-ны ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэгт 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр танилцуулсан. Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эрхлэн явуулах компанийн үйл ажиллагаанд шаардлагатай эхлэлтийн хөрөнгө оруулалт, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал болон Газрын тусгай үйлчилгээний албанаас шилжиж ирэх хөрөнгийн жагсаалтыг гарган, ИНЕГ-ын удирдлагуудад танилцуулсан. ИНЕГ-ын даргын 2017 оны А/202 дугаар тушаалаар хил, гааль, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагуудын оролцоотой нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, хамтран зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг танилцуулж, хилийн хяналтын болон агаарын тээврийн байгууллага тус бүр өөрсдийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулах шийдвэр гаргасан. Хилийн хяналтын болон агаарын тээврийн байгууллагууд 8 удаагийн уулзалт зохион байгуулж, хамтран ажиллаж байна.</p> <p>Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл-ийг хэрэгжүүлэх санал тавьсан Японы консорциумтай хэлэлцээ хийх шатанд байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон Япон Улсын хувийн хэвшил хоорондын харилцан тохиролцох шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэсний</p>



		дараагаар гэрээ байгуулах бөгөөд тухайн өдрөөс хойш 12 сарын бэлтгэл ажлыг хэрэгжүүлснээр шинэ нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэх тул “Чингис Хаан” ОУНБ-ыг нүүлгэн шилжүүлэх тов одоогоор тодорхойгүй байна.
--	--	---

40 хувийн биелэлттэй дараах 3 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

Хүснэгт 3

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
7.2.3	“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам төсөл”-ийн Багц-3: Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгөөр 2017 онд авто замын барилгын ажлыг 50 хувьд хүргэж, 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад оруулна. <u>2017 оны 1-р улиралд</u> зам, барилгын ажлын гүйцэтгэл 7.22%-тай, <u>2-р улиралд</u> зам, барилгын ажлын гүйцэтгэл 7.3%-тай, <u>3-р улиралд</u> зам, барилгын ажлын гүйцэтгэл 19%-тай байна. <u>Жилийн эцсийн байдлаар</u> хөрс хуулалт-62%, далангийн дүүргэлт-45%, ухмал-40%, хөлдөлтөөс хамгаалах үе-30%, суурь-18%, хучилт-2%, хөвөө-1% тус тус хийгдсэн. Нийт зам барилгын ажлын гүйцэтгэл 25%-тай байна.
7.3.3	Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн төмөр замын ТЭЗҮ зураг төслийг боловсруулж дуусгах /Барилгын ажлыг дуусгах/	Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан. “Монголын Алт” ХХК-ийн захиалгаар 2008 онд Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсныг тус компани “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан ТЭЗҮ, зураг төслийг шинэчлүүлсэн. Тус чиглэлийн царигийн өргөний хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлал, ЗГХ-ны тэмдэглэлийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, ЗГ-ын 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр УИХ-д өргөн барихаар тогтсон. Гэвч Засгийн газар эмхлэн байгуулагдсантай холбогдон Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан баримт бичгийг шинэчлэн ирүүлэх чиглэл өгсөн. Үүний дагуу УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Тус чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг тухайн бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч нартай хамтарч шийдвэрлэхээр ажиллаж байна.
7.3.6	Богдхан төмөр замын ТЭЗҮ зураг төслийг боловсруулж дуусгах /ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах/	Богдхан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр ЗТЯ болон АХБ хооронд 2014 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсны дагуу АХБ-наас үзүүлж буй техникийн туслалцаагаар “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй зөвлөх компани “УБТЗ” ХНН-ийн Мандал өртөөнөөс Багахангай чиглэлд шинээр барих “Богдхан” төмөр зам төслийн чигийн судалгааг боловсруулсан. Зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг ЗГ-ын хуралдаанаар батлуулах шийдвэр гарсан. Зөвлөх компани чигийн судалгааны эцсийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14-нд ЗТХЯ-нд хүлээлгэж өгсөн. Тус төмөр замын чигийг ЗГ-ын хуралдаанаар батлуулж, ТЭЗҮ, зураг төслийг боловсруулахаар ажиллаж байна.



4. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2017 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2016 оны 70 дугаар тогтоол батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 74.3%-тай, Засгийн газрын 2017 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 83.2%-тайгаар зөрүүтэй дүгнэгдэж байх тул УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хүрэх түвшинтэй уялдуулан төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал хүргүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газарт;

2. УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан 7.4.2. “Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төв байгуулах бэлтгэл ажлын явцыг 100 хувьд хүргэх” арга хэмжээ ЗГ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, орхигдуулсан байсан тул УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээнүүдийг орхигдуулалгүй төлөвлөгөө батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал хүргүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газарт;

3. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.6-д “Бодлогын зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2 удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол УДААШИРСАН, 3 удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол ТАСАРСАН-д тооцно” гэж заасан тул Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үргэлжлүүлэн тусгагдсан арга хэмжээнүүдийг 2017 оны хагас, бүтэн жилийн хэрэгжилтээс ахиулж, 2018 онд хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтэд хүргэхэд анхаарч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтсүүдэд;

4. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд төмөр замын салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 66.2%-тай дүгнэгдсэн бөгөөд тус арга хэмжээнүүд Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан байх тул хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус зөвлөж байна.

Танилцсан:

Сайд

Ж.Бат-Эрдэнэ

Дэд сайд

Б.Цогтгэрэл

Төрийн нарийн бичгийн дарга

Ж.Бат-Эрдэнэ

Төрийн захиргааны удирдлагын



газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Б.Махбал

Бодлого, төлөвлөлтийн газрын
дарга

Р.Мэргэн

Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Д.Доржханд

Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

С.Батболд

Төмөр зам, далайн тээврийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

Б.Артур

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах хэлтсийн дарга

С.Мөнхнасан

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын ахлах мэргэжилтэн

Н.Буянт